

Айчигийн зорилтыг хэрэгжүүлэх үндсэн чиглэл 2010 - 2020

- Төрийн болон нийгмийн хүчин чармайлтыг биологийн олон янз байдлын хомсдлын шалтгааныг арилгахад чиглүүлэх
- Шууд дарамтыг бууруулж, тогтвортой ашиглалтыг дэмжих
- Биологийн олон янз байдлын хамгааллыг баталгаажуулах замаар түүний төлөв байдлыг сайжруулах
- Биологийн олон янз байдал, экосистемийн үйлчилгээнээс нийтээрээ хүртэх үр шимийг дээшлүүлэх
- Оролцоог хангасан төлөвлөлт, мэдлэгийн менежмент, чадавхийг сайжруулах замаар хэрэгжилтийг хангах

<http://www.cbd.int/sp/targets>

Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөрийн зорилго ба үндсэн чиглэл 2015 - 2025

Монгол Улсын иргэн бүрийн Үндсэн хуулиар олгогдсон эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхийг нь баталгаатай болгох нөхцөлийг бүрдүүлэх зорилготой бөгөөд дараах үндсэн чиглэл баримтална:

- БОЯБ-ын хамгаалал, зохистой ашиглах талаар шийдвэр гаргагч, олон нийтийн мэдлэг хандлагыг нэмэгдүүлэх;
- БОЯБ-ын нөөцийн талаарх шинжлэх ухааны үндэслэлд тулгуурлан зохистой ашиглах болон хамгааллын бодлогыг бий болгон хэрэгжүүлэх
- БОЯБ-ын тогтвортой ашиглах нөхцөлийг хангах
- БОЯБ ба экосистемийн үйлчилгээг хамгаалах ашиглах бодлого, эрх зүйн орчинг сайжруулах.

<https://www.cbd.int/doc/world/mn/mn-nbsap-v2-mn.pdf>

Биологийн олон янз байдлын санхүүгийн санаачилга төслийн зорилго, хүрэх үр дүн 2015 - 2018

БОЯБҮХ-ийг хэрэгжүүлэхэд шаардлагатай болон боломжит санхүүжилтийн зөрөөг тодорхойлж, дутагдалтай санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх арга замыг тодорхойлоход оршино.

Үр дүн 1: БОЯБ-тай холбоотой салбар хоорондын бодлогын төлөвлөлт ба санхүүжилтийг уялдуулах

Үр дүн 2: БОЯБ-ыг хамгаалах засаглал, менежмент болон санхүүжилтийн хэрэгцээг үнэлэх;

Үр дүн 3: БОЯБ-ын санхүүжилтийн төрөл эх үүсвэрүүдийг тодорхойлж нөөц боломжийг дайчлах төлөвлөгөөг боловсруулах

Үр дүн 4: Нөөц боломжийг дайчлах төлөвлөгөөнд тусгагдсан хувилбаруудаас сонгон хэрэгжүүлэх.

<http://www.biodiversityfinance.net/>

НҮБ-ЫН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР

НҮБ-ын байр, Нэгдсэн үндэстний гудамж 14
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар 14201, Монгол Улс
www.mn.undp.org

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

Засгийн газрын II байр, Нэгдсэн үндэстний гудамж 5/2
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар 15160, Монгол Улс
<https://www.mne.mn/>



БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



Empowered lives.
Resilient nations.



This project is co-funded by the European Union



Federal Ministry for the
Environment, Nature Conservation,
Building and Nuclear Safety



NORWEGIAN MINISTRY
OF FOREIGN AFFAIRS



Flanders
State of the Art



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra
Swiss Confederation
Federal Office for the Environment FOEN




Биологийн олон янз байдал гэдэг нь дэлхий дээрх амьд бие организм, тэдгээрийн генетикийн олон янз байдал, шим ертөнц, амьдрах орчин хоорондын хамаарал, харилцан шүтэлцэлийн цогц тогтолцоо юм. Биологийн олон янз байдлын хамгийн чухал үнэт зүйл нь “экосистемийн үйлчилгээ”-г үзүүлдэгт оршдог.

Одоо үед дэлхий дахинд биологийн олон янз байдал урьд хожид үзэгдээгүй хурдастайгаар хомсдож байгаа нь улс орнуудын өмнө хөгжлийн хандлагадаа эрс шинэчлэлт хийхийг шаардаж байна.

Монгол орны нутаг дэвсгэр нь эх газрын эрс тэс уур амьсгал давамгайлсан Сибирийн тайгаас Төв Азийн хуурай хээр, говь цөлийн бүсэд шилжих шилжилтийн бүсэд оршдог учир нилээд өвөрмөц онцлогтой биологийн төрөл зүйлийг бүрдүүлдэг бөгөөд экосистем нь маш эмзэг, гадны нөлөөнд өртсөн тохиолдолд байгалийн жамаар нөхөн сэргэх явц нэн удаан буюу зарим тохиолдолд боломжгүй юм.

Өнгөрсөн зууны хагас хүртэл оршин тогтносон нүүдлийн соёл иргэншил, бэлчээрийн мал аж ахуй нь жилийн 4 улирал, газар нутгийн онцлог байдалдаа нийцсэн байгалийн нэгэн бүрэлдэхүүн хэсэг байв. Үүгээрээ ч өнгөрсөн зууны сүүл хүртэл Монголын байгаль харьцангуй унаган төрхөө хадгалж үлдсэн юм.

Сүүлийн 20 жилд хотжилт, уул уурхайн олборлолт, дэд бүтцийн хөгжил, малын тоо толгойн өсөлт, уур амьсгалын сөрөг нөлөө эрчимжсэн нь Монголын биологийн олон янз байдалд учруулах дарамт эрс өсч үр дагавар нь илт мэдрэгдэх боллоо.



Эх сурвалж: <http://www.mne.mn>



“Биологийн олон янз байдлын тухай” олон улсын конвенцийг батлав.

Конвенцид нэгдсэн 160 гаруй улс орны нэг нь Монгол улс юм.

“Байгаль орчин ба хөгжил” НҮБ-ын хурал 1992 он, Рио де Жанейро хот



2020 онд хүрэх 20 зорилтыг батлав.

Улс орон бүрийг өөрийн улсын биологийн олон янз байдлын хөтөлбөрийг боловсруулах зөвлөмжийг гаргав.

“Биологийн олон янз байдлын тухай” конвенцийн 12-р хурал 2010 он, Японы Айчи муж



Айчигийн зорилтыг хэрэгжүүлэхэд жилд 130-440 тэрбум ам. доллар зарцуулах шаардлагатай тул нөөцийг дайчлах зорилго бүхий дэлхийн түншлэл байгуулагдав. Түншлэлд дэлхийн 30 орон нэгдсэний нэг нь Монгол улс (2015).

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс “Биологийн олон янз байдлын санхүүгийн санаачилга” төслийг 2012 онд эхлүүлсэн.




www.biodiversityfinance.net



Biodiversity is a complex system consists of all living organisms, their genetic diversity, habitats in biosphere and ecosystem diversity. Most important benefit of biodiversity is the ecosystem services. Biodiversity has been deteriorating rapidly, which calls for an urgent change of development prospective.

Mongolian territory spans across the Siberian taiga, Euroasian steppes and the desserts of Central Asia. Due to the transitional ecosystems and harsh continental climatic conditions, the biodiversity in Mongolia is quite delicate, thus natural rehabilitation is very slow and sometimes the negative impacts can be almost irreversible. In addition, the nomadic civilization and pastoral farming has been a unique part of Mongolian biodiversity.

However, during the past 20 years pressures on biodiversity including urbanization, mining, infrastructure development, dramatic increase of livestock number and climate change, have been increased and so does the negative impacts.



<http://www.mne.mn>

<p>"Convention on Biological Diversity" has been approved</p> <p>160 countries including Mongolia ratified the convention.</p>	<p>20 targets to be achieved by year 2020 was approved.</p> <p>A guideline to develop a National Biodiversity Strategic Action plan was approved.</p>	<p>It was estimated that 130-440 billion USD per annum is needed to meet Aichi targets.</p> <p>Global partnership with 30 countries, including Mongolia, was established.</p>	
<p>"Earth summit" UN Conference Rio De Janeiro, (1992)</p>	<p>Global workshop on "Convention on Biological Diversity" Aichi, Japan (2010)</p>	<p>"Biodiversity Finance Initiative" project was launched by UNDP (2012).</p>	<p>www.biodiversityfinance.net</p>

Strategic goals of Aichi targets 2010 - 2020

- Address the underlying causes of biodiversity loss by mainstreaming biodiversity across government and society
- Reduce the direct pressures on biodiversity and promote sustainable use
- To improve the status of biodiversity by safeguarding ecosystems, species and genetic diversity
- Enhance the benefits to all from biodiversity and ecosystem services
- Enhance implementation through participatory planning, knowledge management and capacity building.

<http://www.cbd.int/sp/targets>

National Biodiversity Program 2015 - 2025

Mongolia's National Biodiversity Program has the vision of guaranteeing all citizens' "right to a healthy and safe environment and to be protected against environmental pollution and ecological imbalance" as defined by the Constitution of Mongolia. The strategic goals are:

- Increase awareness and knowledge on Biodiversity conservation and sustainable use among both decision makers and the general public
- Develop and implement science based policy on conservation and sustainable use of biological resources
- Sustainable use of biodiversity
- Improve policies and legal environment for conservation and use of biological diversity and ecological services.

<https://www.cbd.int/doc/world/mn/mn-nbsap-v2-mn.pdf>

Biodiversity Finance Initiative (BIOFIN) outcomes 2015 - 2018

Primary goal of BIOFIN is build a sound business case for increased investment in the management of ecosystems and biodiversity, with a particular focus on the needs and transformational opportunities at the national level. The main outcomes are:

- Component 1:** Integrate biodiversity and ecosystem services in sectoral and development policy, planning and budgeting
- Component 1:** Assess the financing and governance needs for the management and conservation of biodiversity and ecosystem services
- Component 1:** Identify, combine and sequence different funding sources to meet biodiversity financing needs, and develop resource mobilization plan
- Component 1:** Pilot test selected options included in the resource mobilization plan.

<http://www.biodiversityfinance.net/>

UNDP Country Office
UN House, United Nations Street 14
Sukhbaatar District, Ulaanbaatar 14201, Mongolia
www.mn.undp.org

Ministry of Environment and Tourism
Government Building II, United Nations Street 5/2
Chingeltei District, Ulaanbaatar 15160, Mongolia
<https://www.mne.mn/>



MINISTRY OF ENVIRONMENT
AND TOURISM



Empowered lives.
Resilient nations.

Mongolia

BIOFIN

THE BIODIVERSITY FINANCE INITIATIVE

MOBILISING RESOURCES FOR BIODIVERSITY
AND SUSTAINABLE DEVELOPMENT



This project is co-funded by
the European Union




Federal Ministry for the
Environment, Nature Conservation,
Building and Nuclear Safety



NORWEGIAN MINISTRY
OF FOREIGN AFFAIRS



Flanders
State of the Art



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra
Swiss Confederation

Federal Office for the Environment FOEN